

2020 оны В хувилбар

ЭХ ОРОН

Үр хүүхэд минь хар нялхаасаа эх орноо бие сэтгэлдээ тээж, сургууль, ээж, багш нараа, мөр зэрэгцэн суух бяцхан андаа бас сурах бичиг, суудаг ширээ сандал, ангийнхаа цонх, цонхоор харагдах улиас, улиасны мөчир бүхэн, мөчир дээр нь суух бяцхан болжморыг хүртэл Эх орон гэж ойлгосон цагт л бидний оюун санааны амьдрал эхлэх буюу. Эртний их сүмийн туурь, энэ сүм хийдийг яагаад нураасан, хэрвээ алтан ганжир нь үүрийн туяа, өглөөний наранд гялалзаж, сүр жавхлант 700 гаруй сүм хийд монгол нутаг даяар сүндэрлэж, мөргөл өргөлийн дуун эгшиглэж байсан бол... гэсэн бяцхан гуниг боргоцой жаахан үрсийн минь цээжийг эзэмдэж, төрөлх нутгийнх нь уулсад бугын дуу цуурайтаж ахуй цаг дор бид гоо сайхныг цээжний гүндээ мэдэрнэм. Эх орон минь цаст Алтай, сүрлэг Хэнтий, униарт Хангай, шаргал говь, цэнхэр тал төдийгүй Чингис, Чингүнжав, Занабазар, Равжаа, Мянгат, Мандухай, Сүхбаатар хэмээх ойлголтоос бүрднэм. Монгол орныхоо төлөө харийн дайсантай тулалдсан Даваадорж, Тэгшээ нарын баатарлаг зориг, алаг морьтойгоо хүн ардын зүрх сэтгэлд мөнхөрсөн Дандар баатар, Норовбанзадын дуулсан уртын дууны уран нугалаа, өвлийн шөнөөр эмгэн ээжийн ярьсан үлгэр, бударсан цасан дундуур хөтлөлцөн алхах охид хөвгүүд цөм Эх орон юм. Итгэл алдрах бүрдээ би Монголын гайхамшигт баатруудыг санадаг юм. Тэднээс бэрхийг давах хүч тэнхээ авдаг. Морио усалдаг булаг шанд, бутанд хярсан туулай, ялаа шумуул, цагаан дэрс, Явуухулангийн хайр, Чойномын хилэн, Цэрэндоржийн санаашрал, ээжийн минь мөргөл залбирал ч Эх орон юм. Эх орон минь зөвхөн газар шороо, гол мөрөн бус түүх домог, уй гашуу, ялалт, эмгэнэл билээ. О. Дашбалбар

1. Үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

- | | |
|-----------|---------------------------------------|
| 1. ганжир | а. уур бухимдал |
| 2. туурь | б. шашны сүм хийдийн орой дээрх чимэг |
| 3. хилэн | с. эртний сүм хийдийн үлдэгдэл |

- | | | |
|--------------|--------------|---------------|
| A.1a, 2b, 3c | B.1b, 2a, 3c | C. 1b, 2c, 3a |
| D.1c, 2a, 3b | E.1c, 2b, 3a | |

2. Цогцолборуудыг үйл үгээр зөв дараалуулсныг сонгоорой.

- | | | |
|----------------------------------|---------------------------------|--------------------------------|
| A. эхлэх, мэдрэх, санах, амьдрал | B. эхлэх, мэдрэх, санах, мөргөх | C. эхлэх, мэдрэх, мөргөх, авах |
| D. эхлэх, санах, мэдрэх, мөргөх | E. цонх, улиас, мөчир, болжмор | |

3. Чингис, Мандухай, Занабазар, Сүхбаатар зэрэг түүхт хүмүүс аль цаг үед хамаатай вэ?

- | | | |
|--------------------------|--------------------------|--------------------------|
| A. 12, 13, 14, 18-р зуун | B. 13, 16, 17, 18-р зуун | C. 12, 13, 15, 19-р зуун |
| D. 13, 16, 17, 20-р зуун | E. 14, 17, 19, 20-р зуун | |

4. Эхийн сэдвийг түлхүүр үгсээр зөв тодорхойлсныг олоорой.

- | | | |
|--|---|---|
| A. сүм хийд, мөргөл залбирал, мөргөл өргөл, алтан ганжир - шашин шүтлэгийн тухай | B. Сүхбаатар, Даваадорж, Тэгшээ, Дандар баатар - эр зоригийн тухай | C. үр хүүхэд, төрөлх нутаг, Монголын гайхамшиг, цөм - эх орны тухай |
| D. булаг шанд, цагаан дэрс, улиасны мөчир, гол мөрөн - эх байгалийн тухай | E. ялаа шумуул, бяцхан болжмор, хярсан туулай, бугын дуу - ан амьтдын тухай | |

5. Эхийн сэдвээс гол санааг зөв дүгнэснийг сонгоорой.

- | | | |
|--|--|--|
| A. Зөвхөн өвөг дээдэс эр зориг Эх орон юм. | B. Бидэнтэй холбоотой бүхэн Эх орон юм. | C. Бидний орчинд буй зарим зүйл эх байгаль юм. |
| D. Эмгэн ээжийн ярьсан үлгэр л Эх орон юм. | E. Биднээс алсад байгаа зүйл ан амьтад юм. | |

6. “сүрлэг Хэнтий, Чингүнжав, Мянгат, улиасны мөчир, ялалт, эмгэнэл, ялаа шумуул...” зэргээр найруулсны учир юу вэ?

- | | | |
|--|---|--|
| A. өчүүхнээс ч тансаг сайхныг тодорхойлсон | B. ерийнөөс ерийн зүйлийг ч бүлэглэсэн | C. томоос эс ширхэгийг ч хүртэл зүйлчилсэн |
| D. агуугаас энгийн зүйлийг багтааж тоочсон | E. баруунаас зүүн хүртэлх орон зайг харьцуулсан | |

7. “ялаа шумуул....., цагаан дэрс....., ээжийн минь мөргөл залбиралч.....” гэсэнд ямар үгийг хурааж найруулсныг нөхөөрэй.

- | | | |
|-----------------|--------------------|--------------------|
| A. эх орон юм | B. цэнхэр тал юм | C. шаргал говь юм. |
| D. уртын дуу юм | E. алтан ганжир юм | |

8. Өгүүлбэрээс орон зайн уялдаа холбоог зөв тогтоосон хэсгийг сонгоорой.

... сургууль, ээж, багш нараа мөр зэрэгцэн суух бяцхан андаа бас сурах бичиг, суудаг ширээ сандал, ангийнхаа цонх, цонхоор харагдах улиас, улиасны мөчир бүхэн, мөчир дээр нь суух бяцхан болжморыг хүртэл Эх орон гэж ойлгосон

- | | | |
|---|--|--|
| A. цаст Алтай, сүрлэг Хангай, шаргал говь, гоо сайхан | B. ангийнхаа цонх, бяцхан болжмор, улиасны мөчир бүхэн | C. мөр зэрэгцэн суух бяцхан андаа, ширээ сандал, ээж |
| D. мөр зэрэгцэн суух бяцхан андаа, сурах бичиг, улиас | E. цонхоор харагдах улиас, мөчир дээр нь суух болжмор | |

9. Холимог нийлмэл өгүүлбэр дэх “санаж” гэсэн үгийг цагийн утгаар дэлгэрүүлсэн гишүүн өгүүлбэрийг олоорой.

Итгэл алдрах бүрдээ би Монголын гайхамшигт баатруудыг санаж, тэднээс бэрхийг давах хүч тэнхээ авдаг.

- | | | |
|------------------------|---------------------|---------------------|
| A. баатруудыг санах | B. бэрхийг давах | C. хүч тэнхээ авдаг |
| D. итгэл алдрах бүрдээ | E. би тэднээс авдаг | |

10. Онцолсон өгүүлбэрүүд утгын ямар харьцаанд байна вэ?

Алаг морьтойгоо хүн ардын зүрх сэтгэлд мөнхөрсөн Дандар баатар, Норовбанзадын дуулсан уртын дууны уран нугалаа, өвлийн шөнөөр эмгэн ээжийн ярьсан үлгэр, бударсан цасан дундуур хөтлөлцөн алхах охид хөвгүүд цөм Эх орон юм.

А. “Норовбанзад”, “эмгэн ээж” гэх үгс нь хүнийг нэрлэж байгаа учраас зүйлчилсэн утга

В. “өвлийн шөнөөр”, “цасан дунд” гэх үгс нь цаг ба орны утгыг илтгэж байгаа учраас ойролцоо утга

С. “дуулсан дуу”, “ярьсан үлгэр” нь өгүүлэх байдлаараа ижил тул ойролцоо утга

Д. “охид”, “хөвгүүд” гэх үгс нь хүйсээр эсрэг тул эсрэг утга

Е. “хүн ард”, “зүрх сэтгэл” гэх үгс нь хоршин зэрэгцэж бүтсэн тул ойролцоо утгатай

11. “Явуухулангийн хайр, Чойномын хилэн” онцолсон үгсээр юуг төлөөлсөн бэ?

А.найрагчдын ялалт, уй гашуу
D.уран бүтээлийн онцлог

В.амьдралын нэгэн агшин
E.найрагчдын орон зай

С.бүтээл туурвисан цаг хугацаа

12. боргоцой жаахан үрсийн минь” гэсний онцолсон үгээр ямар шинжийг адилтгасан бэ?

А.“бондгор, бомбогор үр” гэсэн хэлбэр төрхийн шинж

В. самрын хонгорцог үр” гэсэн харьяаны шинжээр
E. “боргоцой жаахан” гэсэн овор хэмжээ

С.“хуш модны самрын хонгорцог үр” гэсэн бүтсэн эд

D.“бондгор,бундгар үр” гэсэн төсөөтэй шинж

13. “нугалаа” гэсэн үг эхэд ямар утгаар орсон бэ?

А.хөгжмийн ая хэмнэлийг бууруулах
D.шүлгийн мөр дэх утгын хэмнэл

В.аливаа зүйлийг эвхэн нугалахад тогтсон ором
E.дуу хөгжмийн айзам хөгийн чимэг

С.усны тахиралдан мушгирсан эргүүлэг

14. “Сүр жавхлантай 700 гаруй сүм хийд монгол нутаг даяар сүндэрлэж” гэсний онцолсон үгийг “босож” хэмээх үгээр соливол найруулгад ямар өөрчлөлт гарах вэ?

А.доод найруулгын зэрэгтэй болно
D.найруулгад өөрчлөлт орохгүй

В. хүндэтгэлийн утгатай болно
E. дээд найруулгын зэрэг хэвээр байна

С.найруулгад өөрчлөлт орохгүй

15. “шанд” хэмээх үгийн утгыг зөв тайлбарласныг олоорой.

А.хонхор газарт тогтсон цөөрөм
D.борооны дараах урсгал ус

В.газарт тогтсон их ус
E.устай нүх буюу худаг

С.газраас ундрэн гарах ус

16. “бяцхан андаа эх орон гэж ойлгосон цагт л” гэснээс онцолсон үгийн тэг бүтээврийг олоорой.

А.–ийн
D.–ын

В.–ийг
E. -г

С.–ыг

17. “Бидний оюун санааны амьдрал эхлэх буюу” гэснээс онцолсныг соливол аль нь тохирох вэ?

А. ба
D. юм

В. үгүй
E. хийгээд

С. дээ

18. Утгаараа тохирохгүйг сонгоорой. Лувсангийн сэтгэл уйтгарлана.

А.Хасаг тэрэг шинэчлэгдэхэд
D. Модон тэрэг дуугарах цагт

В. Хасаг тэрэг хяхнах тутам
E. Хасаг тэрэгний хяхнах тутам

С. Хасаг тэрэг хяхнах үед

19. бүтэхгүй, болохгүй” гэсэн утгатай хэлцийг үг нөхөж бүтээгээрэй. Харганы түүж эсгий хийх

А. дэл
D. хөөвөр

В. ноолуур
E. унгас

С. саваг

20. Тохирохыг сонгож нөхөөрэй.

Үдэш орой айлын гэрэл харагдах сайхан

Үрээ морины сайхан

А.хөлөө олох
D.хөл хөнгөрөх

В. хөл алдах
E. хөл газар хүрэхгүй

С.хөл нийлэх

21. Таслалыг зөв хэрэглэснийг олоорой.

А.Өчигдөр таны авчирсан номыг, уншив
D.Өчигдөр таны, авчирсан номыг уншив

В.Өчигдөр таны авчирсан, номыг уншив
E.Өчигдөр таны номыг, уншив.

С.Өчигдөр, таны авчирсан номыг уншив.

22. “сур+валж+л+га” гэснийг зөв залган бичсэнийг олоорой.

А. сурвалжлага
D. сурвалжил

В. сурвалжилга
E. суравжилга

С. сурвалжалга

23. “Харьяалахын тийн ялгалын “-н” нөхцөлийг хос эгшгээр төгссөн үгэнд залгана” гэсэн дүрэмд тохирохыг олоорой.

А.аргын тоолол
D. талбайн хэмжээ

В. ухааны цараа
E. өглөөн нар

С. соёлын өв

24. “ор” язгуураас бүгд үг бүтээх дагавартай хэсгийг сонгоорой

А.-лт, - лого, - мж, - ц
D. -лт, - лого, - мж, - лоо

В. -лт, - лого, - сон, - мж
E. -лт, - в, - ын, - лого

С.-лт, - лого, - мж, - в

25. “Би үзнэ ч, очно ч” гэснээс онцолсон баймж бүтээврийн утгад тохирохыг олоорой.

A. багасган адилтгах
D. ялган онцлох

B. эсрэгцүүлэн онцлох
E. зэрэгцүүлэн онцлох

C. онцлон батлах

26. Ж. Саруулбуян “Бодончар богд” өгүүллэгтээ “*Үзүүр нь хэрэмний чих шиг урт шархялгаастай, жаахан доошлоод бор, улаан, ягаагтар холилдон ууссан үзэмжит уртчихээ хайчлан солбиулна*” гэж өгүүлжээ. Дүрслэлтэй дүйх утгатай /Монголын нууц товчоо/-г сонгоорой.

A. хар хур шувууг бор харцага барьж идэхийг үзэв
D. гол дайрт, годил сүүлт орогшинхул морио унав

B. урагт эс тооцогдох атал энд юу хийж сууна
E. мөчир бүрээс мөч гуя өлгөв

C. үхвэл үхье, амьдарвал амьдарья

27. Үг сонгож, тодорхойлолтыг гүйцээгээрэй

..... гол баатруудынхаа аж амьдралын аль нэг үеийг өгүүлдэг бөгөөд үйл явдал нь романтик адил олон салбарлаж биш дан өгүүлэмжтэй, гол дүрийн явдал нь бусад дүрийн явдалд захирагдмал шинжтэй байдаг.

A. жүжигт
D. өгүүллэгт

B. романд
E. яруу найргийн зохиолд

C. туужид

28. Зохиолын үйл явдал өрнөсөн цаг үеийг олоорой

Манж цэрэг туг далбааг барьцгааж, өвч зэвсэглэж, сүрийг бадруулагч Фү жанжин хуарандаа буу талбин, торгон цэргээрээ хүрээлүүлж Гөлөгдэй баатрын хүрээнд хүрэлцэн ирэв. (Б.Ринчен “ Нууцыг задруулсан захиа “ тууриас)

A. 13-14-р зуун
D. 13-15-р зуун

B. 17-19-р зуун
E. 10-12-р зуун

C. 12-13-р зуун

29. Д. Мягмарын “Үер” туужийн эшлэл дэх онцолсон дүрслэлийн бэлгэдэл юу вэ?

...Залуу эцэг хүүгээ тэвэрсэн хэвээр завинаас үсрэн бууж өвгөний дэргэд харайлган хүрээд босгох гэж өрөөсөн гараараа өргөхөд нялх хүүхдийн часхийх дуу дахин хадаа.

A. амьдралын зам сайхан байх
D. амьдрал мөнхөд тасралтгүй үргэлжлэх

B. удам тасралгүй үргэлжлэх
E. хугацаа мөнхөд үргэлжлэх

C. амьдралын зам шулуун байх

30. Эрээн цоохор” туурийн сэдэв, утга санаатай холбон, хам сэдвийг олоорой.

Сэдэв	Утга санаа
Монгол хүний бүтээлийн тухай	Бичиг үсгээ уламжлан хөгжүүлэх нь залуу хүмүүстэй хамгийн их холбоотой.

A. соёлын
D. шашны

B. нийгмийн
E. улс төрийн

C. түүхийн

31. Өгүүлбэрийг уншаад, онцолсон үгийн утгад тохирохыг сонгоорой.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

32. “ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ” гэсэнд тохирохыг нөхөөрэй.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠬᠦᠨᠢ ᠪᠦᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢᠨ

33. Зөв харгалзуулсныг олоорой.

а. торгоны саа

б. сүйх тэрэг

с. бодож сэтгэ

ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ
ᠪᠣᠳᠣᠵᠤ ᠰᠡᠲᠦᠭᠦ
ᠲᠦᠷᠭᠦᠨ ᠲᠡᠷᠡᠭ

A.1c, 2b, 3a

D.1c, 2a, 3b

B.1a, 2b, 3c

E.1b, 2c, 3a

C.1b, 2a, 3c